



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/76

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу “Эххэрлэн-Ус” ХХК-ий эзэмшлийн Хэрлэн сумын 4 дүгээр баг /Сариг/, Тээвэрчид гудамж Б-21-02 тоот амины ороны сууцны зориулалттай газраас иргэн Өлзийбаяр овогтой Зоригт 703м² газрыг 33 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. “Эххэрлэн-Ус” ХХК, иргэн Ө.Зоригт эзэмшил газрын хэмжээ байршлыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Ө.Зоригт, “Эххэрлэн-Ус” ХХК-ий захирал /А.Боргил/-д тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/309 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010197